

**“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд  
“Өсвөр үеийн дуу хоолой” судалгааны асуулгад дүн шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулах  
судлаач шалгаруулах ажлын удирдамж**

**1. Төслийн товч танилцуулга**

Хүүхдийг Ивээх Сан нь хүүхдийн эрхийг хангах, түүнийг хэрэгжүүлэх замыг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, ашгийн бус, шашны бус, олон улсын төрийн бус байгууллага юм. Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөр нь Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвслийн дэмжлэгтэйгээр “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргүүд болон Говь-Алтай, Ховд аймгуудын ерөнхий боловсролын нийт 14 сургуулийг түшиглэн 2023 оны 01 дүгээр сараас 2025 оны 12 дугаар сарын 31-нийг дуустал 3 жилийн хугацаанд хэрэгжүүлж байна.

**Судалгааны ажлын зөвлөмж боловсруулах ажлын зорилго:** Сургуулийн болон нийгмийн бусад орчинд хүүхдүүдэд тулгамдаад байгаа хүүхэд хамгааллын өнөөгийн нөхцөл байдлын талаар хүүхдүүдээс асуулгын аргаар авсан судалгааны мэдээллийг нэгтгэх, тайлагнах, дүгнэлт, зөвлөмж боловсруулах

**Судалгааны зорилгын хүрээнд дараах гол үр дүнг гаргасан байна. Үүнд:**

- Судалгааны хүрээнд 1000 орчим хүүхдээс 48 асуумж бүхий асуулгаар авсан мэдээллийг нэгтгэх, тоо/чанарын өгөгдлийг SPSS судалгааны программ ашиглан, мэдээлэлд дүн шинжилгээ хийх
- Сургуулийн орчинд хүүхэд хамгааллын асуудлаар тулгамдаж буй нийтлэг асуудлуудыг тодорхойлох
- Сургуулиас бусад нийгмийн орчинд хүүхдүүдэд тулгамдаж буй хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн зөрчлийн талаар нийтлэг асуудлуудыг тодорхойлох
- Гэр бүлийн орчинд хүүхдүүдийн өмнө тулгамдаж буй нийтлэг асуудлуудыг тодорхойлох
- Шийдвэрлэх арга замууд, боломжуудыг тодорхойлсон тайлан, зөвлөмжийг монгол, англи хэл дээр боловсруулах

**Судалгааны зөвлөмж боловсруулах судлаачийн хийж гүйцэтгэх ажил:**

Судлаач нь Хүүхдийн Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөртэй хамтран ажиллаж, дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. Төсөл танилцуулах уулзалтад оролцож, төслийн зорилго болон зорилтуудын талаар мэдээлэл авах
2. Асуулгын аргаар цуглуулсан асуумжуудтай танилцаж, судалгааны ажлын мэдээлэл, файлыг хүлээн авах
3. Судалгааны мэдээллийг нэгтгэх аргазүйг боловсруулж, мэдээлэлд дүн шинжилгээ хийх үндэслэлийг боловсруулах
4. Хүлээн авсан мэдээллийг SPSS руу оруулан кодолж, дүн шинжилгээ хийнэ. Судалгааны зөвлөмж, тайланг англи, монгол хэлээр тус бүр 10-20 хуудсанд багтаан бичнэ.

5. Судалгааны үр дүнг хураангуйлан Power Point Presentation (гол үр дүнгүүд, график, инфографик) хэлбэрээр бэлтгэж төслийн баг, хамтран ажилладаг байгууллагуудад танилцуулна.

#### **Судалгааны хүлээгдэж буй гүйцэтгэлүүд:**

- Судалгааны тайлан, зөвлөмж нь олон улсын стандартын дагуу бичигдсэн байх бөгөөд англи, монгол хэл дээр тус бүр 10-20 хуудсанд (хавсралтууд орохгүйгээр) багтсан байна. Эцсийн тайланг төслийн багт файлаар хүлээлгэн өгнө.
- Судалгааны үр дүнгийн график мэдээлэл бүхий хураангуйлсан хэлбэрийг (Power Point Presentation) англи, монгол хэл дээр бэлтгэн төслийн багт файлаар хүлээлгэн өгнө.
- Судалгааны бусад материал, мэдээллийг (SPSS дата, судалгаанд оролцогчдын нэрс гэх мэт) хавсралтаар төслийн багт хүлээлгэн өгнө.

#### **Судалгаа хийж гүйцэтгэх төлөвлөгөө:**

| <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД</b>                                                                   | <b>ХУГАЦАА<br/>Ажлын 45 хоног</b> |
|--------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------|
| <b>Бэлтгэл үе шат</b>                                                                      |                                   |
| Зөвлөх ажлын нөхцөлийн талаар тохиролцох<br>(Ажлын гэрээ, гүйцэтгэх ажил, хуваарь гэх мэт) | VI/16 – VI/20                     |
| Төслийн зорилго, зорилт, хэрэгжилттэй танилцах                                             |                                   |
| Гэрээнд гарын үсэг зурах                                                                   | VI/19 – VI/20                     |
| <b>Мэдээлэл боловсруулах шат</b>                                                           |                                   |
| Цуглуулсан мэдээллийг хүлээн авах, программд хөврүүлэх                                     | VI/20 – VII/21                    |
| Төслийн багт танилцуулах, холбогдох санал хүсэлтүүдийг тусган засан сайжруулах             | VII/21-VII/23                     |
| Сайжруулсан хувилбарыг төслийн багаар хэлэлцүүлэх, дахин сайжруулах                        | VIII/01-VIII/06                   |
| <b>Судалгааг эцэслэх шат</b>                                                               |                                   |
| Эцэслэсэн материалуудыг ХИС-нд цаасаар болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгөх                | VIII/11-VIII/15                   |
| Хамтран ажиллах гэрээг дүгнэх                                                              | VIII/18                           |

#### **Төслийн багийн удирдлага ба оролцоо:**

Судалгааны дүгнэлт, зөвлөмж боловсруулах үйл ажиллагааны турш ХИС-гийн зүгээс хүүхэд хамгаалал хөтөлбөрийн төслийн зохицуулагч, ХИС-гийн хяналт, үнэлгээний ажилтан болон хөтөлбөрийн бусад ажилтнууд мэргэжлийн туслалцаа дэмжлэгийг үзүүлнэ.

Судлаач нь хүүхэд хамгаалал хөтөлбөрийн төслийн зохицуулагч болон төслийн ажилтан, ХИС—гийн хяналт үнэлгээний ажилтанд ажлын гүйцэтгэлийн тайлан, мэдээллийг тогтмол явуулна.

#### **Судлаачид тавигдах шаардлага:**

- Судлаач нь хүүхдийн эрх, хамгаалал, нийгмийн хамгааллын чиглэлээр мэргэшсэн, энэ чиглэлийн судалгааг хийж гүйцэтгэсэн, удирдаж байсан туршлагатай байх
- Судлаач холбогдох чиглэлээр магистраас доошгүй түвшний зэрэгтэй байх
- Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрт ажиллаж байсан бол давуу талтай

- Тоон болон чанарын судалгааг хослуулан гүйцэтгэж байсан 5-аас доошгүй жилийн мэргэжлийн туршлагатай байх
- Тайлан, зөвлөмж бичих өндөр чадвар эзэмшсэн байх
- Байгууллага болон төсөлд сургамжтай мэдээллийг судалгаанд үндэслэн боловсруулж байсан туршлагатай байх

#### **Бүрдүүлэх материал:**

- Судалгааны зөвлөмж боловсруулах ажлыг гүйцэтгэх сонирхлыг илэрхийлсэн захидал.
- Судалгааны боловсруулалт хийх ажлын төлөвлөгөө (хугацаа, аргазүй, аргачлал, зохион байгуулалт зэрэг).
- Судлаачийн анкет, ажлын туршлагыг харуулсан мэдээллүүд.
- Судалгааны зөвлөмж боловсруулах ажлын үнийн санал, төсөв (судалгааны аргазүй, төлөвлөгөөнд нийцсэн байна).

Сонирхол бүхий судлаач бүрдүүлэх материалыг битүүмжлэн, 2025 оны 6-р сарын 06-ны 17.00 цагаас өмнө дараах хаягаар ирүүлнэ үү.

**Хаяг:** Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона Төв, 4-р давхар, Хүүхдийг Ивээх Сан. (Хүнсний 20, Мөнгөнзавъяа дэлгүүрийн хойно, ЕБ-ын 23 дугаар сургуулийн урд талд)

**Лавлах утас:** +976-11-329365, +976-11-329371